

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ.....	3
1.1. Байгууллагын мэдээлэл	3
1.2. Төслийн танилцуулга мэдээлэл	3
1.2.1. Талбайн байршил.....	3
1.2.3. Төслийн танилцуулга, хүчин чадал	4
1.3. Төслийн дэд бүтэц.....	6
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1. Байгаль орчны онцлог.....	8
2.2. Нийгэм эдийн засаг	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	11
3.1. Агаарын чанар	11
3.2. Хөрсөн бүрхэвч	11
3.3. Гадаргын болон газрын доорх ус.....	12
3.4. Ургамлан нөмрөг.....	12
3.5. Амьтны аймаг	12
3.6. Тусгай хамгаалалттай газар нутаг	13
3.7. Нийгэм эдийн засаг	13
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	14
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө/ ургамлан нөмрөг хамгаалах	16
4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	17
4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
4.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	20
4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө.....	21
ДҮГНЭЛТ.....	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Талбайн байршлын зураг	3
Зураг 2. Төслийн талбайн өнөөгийн харагдах байдал	4
Зураг 3. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлтийн зураг	6

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн эргэлтийн цэг	4
Хүснэгт 2. Барилга байгууламжийн талбайн хэмжээ	5
Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	14

1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ


1.1. Байгууллагын мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Экспокс” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011239089
Регистрийн дугаар	5385962
Хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, дүнжингарав, 105/5 тоот
Холбоо барих утас	8811-5701, 99092612

1.2. Төслийн танилцуулга мэдээлэл

1.2.1. Талбайн байршил

“Палм спрингс” аялал жуулчлалын цогцолбор төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн, 8-р хороо, Богдхан уулын ДЦГ-ын Жаргалантын аманд хэрэгжиж байна.



ЗУРАГ 1. ТАЛБАЙН БАЙРШЛЫН ЗУРАГ



ЗУРАГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ХАРАГДАХ БАЙДАЛ

Хүснэгт 1. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЭРГЭЛТИЙН ЦЭГ

№	Тэгш өнцгийн солбицол		Газарзүйн солбицол		Талбай, га
1	5296388.95	637761.26	106° 50' 23.726" E	47° 48' 21.976" N	6.06
2	5296502.64	687775.75	106° 50' 24.552" E	47° 48' 25.646" N	
3	5296449.86	638070.29	106° 50' 38.646" E	47° 48' 23.709" N	
4	5296310.17	638135.39	106° 50' 41.615" E	47° 48' 19.137" N	
5	5296219.64	638118.51	106° 50' 40.699" E	47° 48' 16.219" N	
6	5296244.94	638038.30	106° 50' 36.874" E	47° 48' 17.100" N	

1.2.3. Төслийн танилцуулга, хүчин чадал

“Palm springs resort and villa” нь сингл хаус, таун хаус, гэр бүлийн гишүүн бүрт зориулагдсан клуб хауснаас бүрдэнэ.


Тус аялал жуулчлалын цогцолбор нь Улаанбаатар хотын Богдхан уулын ДЦГ Жаргалантын аманд байрлах бөгөөд жилийн дөрвөн улирал үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Уг цогцолбор нь 1 ширхэг клуб хаус үйлчилгээний барилга, 18 ширхэг амралтын байр, 26 ширхэг 2 давхар хаус, цэцэрлэгт хүрээлэн, спортын талбай нийт 6.06 га талбайд баригдахаар төлөвлөгдсөн.

Одоогоор 23 хаус ашиглалтад орсон бөгөөд энэ ондоо нэмэлтээр 8 хаус ашиглалтад ороход бэлэн болсон байна. Үлдсэн барилга, байгууламжийн гадна, дотор болон нарийн засварын ажлыг 2024 ондоо багтаан дуусган бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Нийт талбайн 70 хувьд ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбай байхаар төлөвлөсөн ба энэ нь оршин суугчдын амрах, алжаалаа тайлах, хүүхдийн чөлөөт цагийг эрүүл, цэвэр цэмцгэр орчинд зөв зохистой өнгөрүүлэх, тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж байна.

Хүснэгт 2. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

№	Хаусны код	Талбайн хэмжээ, м ²	Нүүрэн талын харагдах байдал
1	A1-A4	268.09	
2	A5-A13	283.54	
3	B1-B7	222.36	
4	C1-C7	184.12	

5	Town house	126.24	
---	------------	--------	------------------------------------------------------------------------------------



ЗУРАГ 3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГ

1.3. Төслийн дэд бүтэц

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 сарын 31-ны өдрийн А/331-р тушаалын дагуу аюултай болон энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах талаар; хүлэмжийн хийг бууруулах зорилгоор эрчим хүчний шийдлийг байгальд ээлтэй технологи ашиглаж халаалт, дулааны асуудлыг шийдвэрлэх боломжийг төсөлд тусгах; байгаль орчинд халгүй, хөрсний бохирдол үүсгэдэггүй ариун цэврийн байгууламж байгуулах, төслийн цар хүрээнээс хамааран бага оврын цэвэрлэх байгууламж тусгах гэж заасны дагуу дээрх дэд бүтцийг төлөвлөн тусгасан болно.

Усан хангамж

Аялал жуулчлалын цогцолборын хүрээнд амрагч, ажиллагсдын унд ахуйн усыг өөрийн талбайд гаргуулсан гүний худгаас хангана. Гүний худгийн ундарга нь 1л/сек, гүн 100м, солбицол $47^0 80 69,19$, $106^0 84 03,39$ байна.

Цахилгаан хангамж

Цахилгаан хэрэглээгээ нэгдсэн сүлжээ буюу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний өндөр хүчдэлийн шугамаас трансформатор байгуулсаны үндсэн дээр цахилгааны эх үүсвэр авч шаардагдах газрууд руу далд холболтоор хүргэснээр төвийн өдөр тутмын цахилгаанаар хангана.

Харилцаа холбоо

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь үүрэн телефоны бүхий л сүлжээг ашиглах боломжтой бөгөөд үйл ажиллагаандаа дотоод сүлжээгээр барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын системийг ашиглана.

Дулаан хангамж

MNS 6426:2013 стандартын дагуу “Байр сууцны хана, дээвэр, шаланд дулааны алдагдал багатай материал ашиглах ба барилгын хаалга, цонхны холбогдох стандартуудын шаардлага хангасан байна. Мөн эрчим хүчний хэрэглээний 30-аас багагүй хувийг сэргээгдэх эрчим буюу нар, салхины эрчим хүчээр хангана. Гадна талбайн гэрэлтүүлэгт хөдөлгөөний мэдрэгчтэй, нарны зайгаар ажилладаг гэрэл ашиглана.

Халаалтын систем Монгол орны эрс тэс уур амьсгалд халаалтын систем амин чухал систем юм. Халаалтын системийг үр өгөөжтэй байлгахын тулд байшингийн дулаан алдагдалыг бууруулж, бүрэн автомат зөв халаах төхөөрөмжийг сонгох шаардлагатай.

2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Байгаль орчны онцлог

Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн тойргуудын мужлалаар Улаанбаатар хот нь Дагуур-Монголын хээрийн их мужийн Дагуурын уулын хээрийн мужид хамаарагдана.

Улаанбаатар хот урдуураа Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг, баруугаараа мөн аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянцогт, баруун хойгуураа мөн аймгийн Батсүмбэр, зүүн хойгуураа, зүүгээрээ мөн аймгийн Батсүмбэр, зүүн хойгуур, зүүгээрээ мөн аймгийн Эрдэнэ сумтай хиллэдэг.

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны урд үзүүр болох Баянзүрх, Богд хан, Сонгино хайрхан, Чингэлтэй хайрхан уулсаар зүүн, урд, баруун, хойд талаараа тус тус хүрээлэгдсэн бөгөөд Туул, Сэлбэ голуудын бэлчир хөндийд байрладаг.

Дунджаар далайн түвшнээс дээш 1351 м өндөрт оршдог. Нийт 4,704.4 км² нутагтай ба газар хөдлөлтийн ерөнхий мужлалаар VIII баллын газар хөдлөлтийн мужид байрлаж байна.

Улаанбаатар хот орчим нь уур амьсгалын хуурайдуу сэрүүвтэр мужийн нэн хүйтэн дэд мужид хамрагдана. Уур амьсгалын үндсэн нөхцөл нь хоног, сар, жилийн агаарын температурын агууриг их, агаарын чийгшил бага, хур тунадасны хуваарилалт жигд бус, зундаа их халж, өвөлдөө их хүйтрэх зэрэг эх газрын эрс тэс уур амьсгалаар тодорхойлогдоно.

Жилийн дундаж температур нь -1.3°C. Богино, дулаан зунтай бөгөөд урт, маш хүйтэн, хуурай өвөлтэй. Жилийн дундаж хур тунадас нь 242.7 мм, дундаж чийгшилт нь 69% байна.

2.2. Нийгэм эдийн засаг

Улаанбаатар хот нь Монгол Улсын Нийслэл юм. Засаг захиргааны хувьд Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Налайх, Багануур, Багахангай гэсэн 9 дүүрэгт хуваагддаг. Дүүрэг бүр нь хороодод хуваагдана. Налайх, Багануур, Багахангай гэсэн 3 дүүрэг нь хотын төвөөс алслагдсан байдаг.

Төсөл байрлах Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар “Ажилчны район” нэртэйгээр байгуулагдсан нийслэлийн ууган дөрвөн дүүргийн нэг юм.

Нийт 50351 га газраас иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн нийт 822.2 га, иргэний гэр хорооллын эзэмшилд нийт 1142.7 га, төрийн байгууллагын эзэмшилд нийт 245.3 га, аж ахуйн нэгжийн эзэмшилд 1775.2 га, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн ашиглалтанд 55.7 га, хөдөө аж ахуйн эзэмшил, ашиглалтанд нийт 958.5 га, хот тосгон бусад суурин газрын эзэмшил, ашиглалтанд нийт 2878.2 га тус тус байна.

Мал аж ахуй: Хан-Уул дүүрэгт 2022 оны мал тооллогоор нийт 46068 толгой мал тоологдсон нь 2021 оноос 3201 (7.5%) толгой малаар өссөн байна. Нийслэлийн хэмжээнд 2022 онд 442841 толгой мал тоологдсон бөгөөд 10.4 хувийг Хан-Уул дүүргийн мал эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд тоологдсон малын тоогоор 27081 толгой малаар 14-р хороо тэргүүлсэн бол хамгийн цөөн малтай нь 12-р хороо 4328 толгой малтай байна. 2022 онд нийт мал сүргийн 39.8 хувийг бог мал, 60.2 хувийг бод мал эзэлж байна. Нийт мал сүргийн 0.04 хувийг тэмээ, 33.5 хувийг адуу, 26.7 хувийг үхэр, 19.9 хувийг хонь, 19.9 хувийг ямаа эзэлж байна. Бог малын бүтцийн хувьд нийт бог малын 50.0 хувийг хонин сүрэг, 50.0 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Газар тариалан: Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага 2022 онд 10.7 га талбайд төмс, 123.1 га талбайд хүнсний ногоо тус тус тариалжээ. Нийт 26.1 га хүлэмжийн талбайд ногоо тарьсны 57.9 хувийг өргөст хэмх, 8.8 хувийг улаан лооль, 33.3 хувийг бусад хүнсний ногооны тариалалт эзэлж байна. 2021 онтой харьцуулахад хүнсний ногоо тариалалт 27.7 га талбайгаар нэмэгдсэн.

Нийслэлийн хэмжээнд хураасан нийт төмс, хүнсний ногооны 28.1 хувийг Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгж хураан авчээ. Дүүргийн хэмжээнд 2022 онд хураасан нийт ургацын 95.5 хувийг 13-р хороо, 4.0 хувийг 14-р хороо, 0.08 хувийг 12-р хороо, 0.42 хувийг бусад хорооны ургац хураалт тус тус эзэлж байна.

Цахилгаан хангамж: Улаанбаатар хотын аж үйлдвэр, нийгэм ахуйн хэрэглэгчийг Монгол улсын төвийн эрчим хүчний системээс буюу 2-р, 3-р, 4-р цахилгаан станцаас цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Эдгээр станц нүүрсээр ажилладаг бөгөөд үр ашгийн түвшин нь олон улсын стандартаас доогуур байна. Төвийн эрчим хүчний системийн цахилгааны алдагдал ихээхэн өндөр байна.

Зам тээвэр: Хан-Уул дүүрэгт тээврийн хэрэгслийн зонхилох арга нь авто машин (хэсгүүдийн 43%) гэж мэдээлсэн. Замын хөдөлгөөнтэй холбоотой гарч болзошгүй бүх асуудал бүртгэгдсэн байна. Дүүргийн хэмжээнд замын хөдөлгөөний хамгийн хүндрэлтэй асуудал нь ачаалал хэт ихтэй (22%), дараа нь зогсоолын хүрэлцээ муу (16%) байна. 2-р хороонд замын хөдөлгөөний ачаалал их байгаа нь хамгийн гол асуудал гэж хэсгийн хороодын 82 хувь нь мэдээлжээ. Төслийн талбай нь хатуу хучилттай авто замын хажууд байрлана.

Усан хангамж: Нийслэл Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэр аж ахуйн газрын усны хэрэглээг:

- 1) Дээд эх үүсвэр 51.800 м³/хоног,
- 2) Төвийн эх үүсвэр 125.200 м³/хоног,
- 3) Үйлдвэрийн эх үүсвэр 30.300 м³/хоног,
- 4) Мах комбинатын эх үүсвэр 8.600 т³/хоног, нийт 215.900 м³/хоног гэсэн нөөцтэй эх үүсвэрүүдээс хангадаг.

Хотын шугам сүлжээний систем нь дөрвөн эх үүсвэрээс зэрэг хангагддаг нэг бүсчлэлийн системтэй. Гэр хороолол нь усан хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд бүрэн холбогдоогүй ба ус түгээх цэгүүдээс болон зөөврийн усаар хангагддаг.

Боловсрол: Хан-Уул дүүрэгт төрийн өмчийн 18, төрийн бус өмчийн 25, Албан бус насан туршийн боловсролын төв 1, нийт 44 сургууль сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд төрийн өмчийн сургуулийн 817 бүлэгт 31174, төрийн бус өмчийн сургуулийн 460 бүлэгт 9618, нийт 1277 бүлэгт 40792 суралцагч бага, суурь, бүрэн дунд боловсролын үйлчилгээг авч байна. Төрийн өмчийн сургуульд 1208, төрийн бус өмчид 669, нийт 1877 багш, 981 ажилтан ажиллаж байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Экспоке” ХХК-ийн аялал жуулчлалын цогцолбор төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Хүмүүс олноор төвлөрөн бөөгнөрөх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнтэй уялдан хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг талхагдалд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх
- Төслийн барилга байгууламжыг барьж байгуулах үед эдэлбэр газар, хөрс эвдрэлд орох, ургамал талхлагдах
- Шингэн хаягдалыг ил задгай хаясан тохиолдолд гадаргын ус болон хөрс, ургамал бохирдох
- Хийн хаягдал агаар орчинг бохирдуулах

Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, ургамал байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурьдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллах хэрэгтэй.

3.1. Агаарын чанар

- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох
- Барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтанд ажиллах машин механизмуудын утаа
- Агаар дах тоосны агууламж ихсэн хүний эрүүл мэндэд нөлөөлөх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм

3.2. Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Төслийн барилга байгууламжийн үйл ажиллагаа явагдах үед м² талбайн хөрс ургамал эвдрэлд орох
- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босож орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, явган хүн болон автомашины зам талбайг цементлэх, тохижуулах
- Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрд ачуулах, ангилан ялгаж байх

3.3. Гадаргын болон газрын доорх ус

“Палм спрингс” аялал жуулчлалын цогцолбор барилгын ажлын үед техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлээс үүсч болзошгүй тос тосолгооны материал, шатах тослох материал санамсар болгоомжгүйгээр хөрсөнд асгарч алдагдсанаар гадаргын болон газрын доорх усыг бохирдуулж болзошгүй. Мөн барьж байгуулах үед болон үйл ажиллагаа явуулахдаа ажилчид болон амрагчид хог хаягдлыг ил задгай хаяснаар гадаргын болон газрын доорх усны бохирдлыг үүсгэж болзошгүй. Төслийг хэрэгжүүлэхэд гүний усыг ашиглах нь гүний усны нөөцөд тодорхой хэмжээгээр нөлөөлөх болно.

3.4. Ургамлан нөмрөг

Ургамлын аймгийн хувьд Хэнтийн уулын тайгын тойрогт багтаж байна. Энэ тойрогт Дорнод Сибирийн болон Дагуурын Тайга, өндөр уулын ургамлын аймгийн төлөөлөгчид голчлон тохиолдоно. Энд алаг өвст үетэнт сорвоот улалжит бүлгийн хэв шинжүүд голлоно. Нийт 70 овгийн 256 төрлийн 587 зүйл цоргот ургамал ургадаг.

Ургамлын амьдралын гол нөхцөл болсон гэрэл, дулаан, усан хангамж, хөрсний бүтэц, эрдэс тэжээл, агаарын хүчилтөрөгч хангамжаас шалтгаалан ургамлын бүтэц-экологийн өвөрмөц бүлгүүд бий болсон байдаг.

Барилга байгууламж барих болон төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр /Амрагч жуулчдын хөл хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг/ зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарч, орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдаж, тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх

3.5. Амьтны аймаг

Төслийн талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Хэнтийн уулын тайгын тойрогт багтана. Хэнтийн тайгын голлох элемент болох олон зүйлийн хөхтөн амьтдын тархалттай. Богдхан уул амьтны газарзүйн хувьд тайга, ойт хээр, хээр тал, ус намаг, хад асга, хот суурин, интросиаль янз бүрийн ландшафт, амьдралын экологийн олон онцлогуудыг агуулснаараа шавьж, шувуу, хөхтөн амьтдын өвөрмөц цогцолбортой.

Төслийг барилгын ажлын үе болон хэрэгжүүлэх хугацаанд амрагчдын тоо, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлнэ.

“Экспокс” ХХК-ийн “Палм спрингс” аялал жуулчлалын цогцолбор байгуулах талбай нь хот суурин газраас холгүй мөн авто замд ойр орших тул зэрлэг амьтад ховор тааралдана.

Барилга барих үйл ажиллагааны улмаас тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, барилга байгууламжуудыг барих явцад амьтдын нүх, үүр сүйтгэгдэх, үүрнээсээ дайжиж болзошгүй юм. Төсөл хэрэгжсэнээр хүн амын суурьшлыг дагаад хоол хүнсний хаягдлаар хооллодог бор шувуу, хэрээ зэрэг суурин газрын шувуудын цугларалтыг нэмэгдүүлж болох юм. Энэ нь шувууд халдварт өвчин тархаах нөхцөлийг бүрдүүлж болзошгүй юм.

3.6. Тусгай хамгаалалттай газар нутаг

Богдхан уулын Дархан цаазат газар нь нийслэл хотын дэргэд байрладаг, дэд бүтэц илүү сайн хөгжсөн, байгалийн иж бүрдлийг төлөөлсөн үзэсгэлэн төгөлдөр олон амуудтайгаас гадна хадны сүг зураг, Мэргэн Тоньюкийн хөшөө сүм, хийдийн суурь, туурь зэрэг түүх, соёлын дурсгалт газрууд олонтой юм.

Цармын ой хээрийн болон нугын хэв шинжит хамаарах уррамлын нөмрөгтэй бөгөөд нийт талбай нь 55,8% буюу 22,9 мянган га газрыг ой мод эзэлнэ. Үүнээс шинэс 56,8%, хуш 22,2%, гацуур 15,4%, нарс 1,4%, хус 2,6%, бут сөөг 1 хувийг тус тус эзэлнэ.

3.7. Нийгэм эдийн засаг

Төслийн барилгын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь ойролцоо нутаглах иргэдэд үзүүлэх болно. Нутгийн иргэдийн ашигладаг худгийн ойролцоо гүний усыг ашигласнаар бага гүний усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээсэн.

Иймд 2021 онд мэргэжлийн эрх бүхий “Хас цаг” ХХК-иар боловсруулсан менежментийн төлөвлөгөөний дагуу 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29- ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хянан батлах журмыг баримтлан боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2024 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 15,591,500 төгрөг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хэрэгжүүлэх арга хэмжээ		Нийт зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,350,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	6,700,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	900,000
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	6,400,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	241,500
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
Нийт		15,591,500

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
АГААР ОРЧИН								
Богд хан уулын ДЦГ орчмын авто тээврийн хөдөлгөөн ихэссэнээс агаар дахь тоосны хэмжээ CO, SO ₂ , NO ₂ ихсэж, орчны хүчилтөрөгчийн /O ₂ / хэмжээ багасах, үйлчлүүлэгч иргэд, аялагчдын автомашины шатах тослох материалын ууршилт, утаа тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчинг бохирдуулах, ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно. - Барилга байгууламж барих үеийн газар шорооны ажлаас тоосжилт үүсэх.	Баазын талбайд барилгын ажлын үед болон цаашид хуурайшилттай үед тоосжилт үүсэхээс сэргийлж газрын гадаргыг чийгшүүлж байх	Төслийн хүрээнд	удаа	10.0	10	100.0	Тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Агаарын тухай хууль • MNS 4585:2016 • MNS 4990:2023 • MNS 5885:2008
	Тоосжилт бууруулах зорилгоор төв зам хүртэлх замыг хатуу хучилттай болгох хайрга чулуу дэвсэх	Төслийн хүрээнд	удаа	500.0	-	500.0	2024 он	
	Агаарын бохирдлын /CO, SO ₂ , NO ₂ , Тоос/ шинжилгээ хийлгэж байх		Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгав.					
ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС								
Төслийн барилгажилтын үе шатанд /цэвэр бохир усны шугам, / гадаргын болон гүний усанд нөлөөлөх, Шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, Бохир ус дамжуулах шугам хоолойг зориулалтын бус материалаар хийх, шугам хоолойд гэмтэл үүсэж гүний усыг бохирдуулж болзошгүй.	Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг хянах, тухай бүр нэн даруй засвар хийх	Төслийн хэмжээнд	-	100.0	-	100.0	Тухай бүр	<ul style="list-style-type: none"> • Усны тухай хууль • Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
	Ус хэрэглээний бүртгэл хөтлөх. Ус дамжуулах хоолойд тоолуур тавих	-						

БОГДХАН УУЛЫН ХЯЗГААРЛАЛТЫН БҮС ЖАРГАЛАНТЫН АМАНД БАЙРЛАХ “ПАЛМ СПРИНГС” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгж зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ								
Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс байгууламжуудын дор дарагдаж, зам тээвэр, бүтээн байгуулалт болон бусад үйл ажиллагаатай холбогдож элэгдэл, эвдрэлд өртөнө. Барилгын ажлын улмаас хаягдлаар хөрс бохирдож болзошгүй	Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, /төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх/	Үйл ажиллагааны турш	удаа	150.0	-	150.0	2024 он	<ul style="list-style-type: none"> Газрын тухай хууль MNS5850:2019 MNS4597:2014 MNS4759:2014
	Төслийн объектууд хооронд явган хүний зам тавих (өнгөт хавтан, чулуу г.м), сэргээн засварлаж байх		удаа	500.0	1	500.0	2024 он	
	Цогцолборын ойр орчмын талбайд ургамал талхлагдсан газруудад олон наст ургамлын үр тариалж ургамалжуулах		тогтмол	Үйл ажиллагааны зардлаар		Хавар 5-аас 6 сард	<ul style="list-style-type: none"> MNS 5918:2023 	
	Авто зогсоолыг тохижуулахдаа хөрсийг хуулан 3-5 см зузаан шавар үеийг нягтаршуулан болзошгүй тохиолдлоор бензин, тос гоожих, асгарах нөхцөлд доош хөрсөнд нэвчихээс хамгаалсан хаалт (екран) хийн дээрээс нь цардсан (цементэн) хучлага хийж өгөх		Үйл ажиллагааны зардлаар		<ul style="list-style-type: none"> MNS 5916:2008 			
	Ил гал түлэх, түүдэг гал асаах тохиолдолд газрыг 50-70 см хүртэл гүн, 2,5-3,0 м диаметртэй талбайг ухаж хайрга, чулуун дүүргэвч хийж зориулалтын байдлаар тохижуулж ашиглах		Үйл ажиллагааны зардлаар					
Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний зардал						1,350,000		

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө/ ургамлан нөмрөг хамгаалах

Тус аялал жуулчлалын цогцолбор байгуулах төслийн онцлогоос хамааран нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн талбайн ногоон байгууламжыг байгуулах болон түүний арчилгаа, тордолгоо хийх ажлыг оруулсан.

БОГДХАН УУЛЫН ХЯЗГААРЛАЛТЫН БҮС ЖАРГАЛАНТЫН АМАНД БАЙРЛАХ “ПАЛМ СПРИНГС” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээж, ногоон байгууламж бий болгох	Нийт ашиглалтын талбайн 70%-д ногоон байгууламж байгуулах	Нийт талбайд	Голт бор 290 ш, Жимсний мод 10 ш	290ш*20.0= 5 800.0 10ш*40.0=400.0	6 200.0	Хавар, намрын улиралд	<ul style="list-style-type: none"> • MNS5916:2008 • MNS5914:2008 • MNS5918:2023
2	Тоосжилтоос сэргийлэх зорилгоор орчныг тохижуулж, зүлэгжүүлэхэд тогтмол усалгаа хийх	Ногоон байгууламжийн усалгаа, тайралт, хэлбэржүүлэлт хийх	Төсөл хэрэгжих орчинд	-	500.0	500.0	Үйл ажиллагааны турш	
Нийт						6,700,000		

4.3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах,	Төслийн талбай	-	300.0		Үйл ажиллагааны турш	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай • MNS 4968:2000 /Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага/
		Хамгаалалтын далан, жалга сайрыг цэвэрлэж байх	Төслийн талбай орчим	-	50.0	100.0	Жилд 2 удаа	
2	Байгаль орчин бохирдох	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Бүх ажилчдад	удаа	200.0		Жилд 1 удаа	<ul style="list-style-type: none"> • Гамшгаас хамгаалах тухай хууль, • “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”
3	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Төслийн хүрээнд		200.0		-	<ul style="list-style-type: none"> • Галын аюулгүй байдлын тухай хууль • Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
		Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	1	50.0	100.0	Жилд 2 удаа	• MNS 6576:2016 /Гал түймэртэй тэмцэх. Гал түймэр унтраах даралтын хоолой. Техникийн шаардлага/
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал					900,000			

4.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлыг зориулалтын саванд хадгалах, ангилан ялгах, ажиллагсаддаа энэ чиглэлээр сургалт явуулах зэргийг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгаж ажиллах шаардлагатай.

- Аж ахуйн сайн дадлыг хэвшүүлж, хог хаягдлаас үүдэлтэй эрүүл мэнд болон аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах, арилгах,
- Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын хэмжээг бүртгэхэд анхаарах, бүртгэл дээр үндэслэн хог хаягдлыг бууруулах боломжийг эрэлхийлэх,
- Ажилтан албан хаагчид байгаль орчныг хамгаалах, ажлын байрны эрүүл ахуй, цэвэр байдлыг хангах үүргээ ухамсарлан хог хаягдлыг багасгах, ангилан ялгаж байгаа эсэхэд анхаарлаа хандуулдаг байх,
- Төслийн үйл ажиллагааны явцад хог, хаягдлын менежментийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, байгаль орчин, эрүүл ахуйд нөлөөлөл багатай байх нөхцөлийг бүрдүүлж, байнга сайжруулах.
- Хог хаягдлыг бууруулах, багасгах арга хэмжээний хүрээнд онц шаардлагагүй хог хаягдал бий болгохоос зайлсхийх, хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллах.

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
Хог хаягдлыг ил задгай хаяснаар орчны	Хог хаягдлын эх үүсвэр бүрт тухайн хог хаягдлыг агуулах бүрэн боломжтой бат бөх зөөврийн хогийн сав байрлуулах	Төслийн талбай	20 ш (120л багтаамжтай)	120.0	2 400.0	2024 он	- “Хог хаягдлын тухай хууль” - MNS 5344:2003 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага

БОГДХАН УУЛЫН ХЯЗГААРЛАЛТЫН БҮС ЖАРГАЛАНТЫН АМАНД БАЙРЛАХ “ПАЛМ СПРИНГС” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
бохирдол үүсгэх	Ахуйн хатуу хог хаягдлын түр цэг байгуулах, хог хаягдлыг ангилан ялгах боломжтой хогийн сав байрлуулах		1 ширхэг иж бүрэн (3 тасалгаатай)	4 000.0	4 000.0	2024 он	- БОАЖС-ын 2018 оны А/428 дугаар тушаалаар батлагдсан “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам” - Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар 10.2.3, 10.2.4
Шингэн хог хаягдал хөрсөнд нэвчиж, хөрс бохирдуулах	Цэвэрлэх байгууламжийн бохир усыг соруулах	Цэвэрлэх байгууламж	удаа	Үйл ажиллагааны зардлаар		Тухай бүр /ЦБ-ийн танк 70%-аас дээш дүүрэх бүрд/	
Хог хаягдлын менежментийн зардал				6,400,000			

4.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Тайлбар	Баримтлах стандарт
	1	2	3	4	5	6	7	8
УСАН ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
1	~ Усны ерөнхий шинжилгээ	мг/л	Унд ахуйн уснаас	Жилд 2 удаа	Усны ерөнхий химийн үзүүлэлт- 46.0	46.0*1 цэг*2 удаа= 92.0	Газарзүй, Гео-экологийн хүрээлэн	- MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага - MNS 0900:2018 Ундны усны стандарт
2	~ Гүний худаг уны нөөцийн болон бохирдлын хянах төхөөрөмж суурилуулах		Гүний худагт	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаар			
ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
2.	~ Хөрсний физик, химийн шинж чанар ~ Хөрсний хүнд металлын агууламж	мг/кг	Төслийн талбайд нэг цэг сонгох	Жилд 1 удаа	45.0	45.0	Грийн лаб хөрс судлалын лаборатори	- MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт - MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томьёо, тодорхойлолт
АГААР ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ								
3.	~ Азотын давхар исэл (NO _x) ~ Хүхэрлэг хий (SO ₂)	мкг/м ³	Хяналтын цэг	Жилд 1 удаа	- Багажийн түрээсийн зардал=40.0 - NO _x = 12.5 - SO ₂ =12.0 - Нийт тоос (TSP)=20.0* 2 цэгт=40.0	104.5	БОХЗТЛ-аар гүйцэтгүүлнэ.	- MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага - MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
	~ Агаарын тоос тоосонцор (TSP)		2 цэгт					
	~ Дуу чимээ	дБА	Хяналтын цэг					
Орчны хяналт, шинжилгээний зардал						241,500		

4.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан
		2024 он				
		I-улирал	II-улирал	III-улирал	IV-улирал	
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, ДЦГ-ын хамгаалалтын захиргаа болон байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	-	+	+	+	+	Удирдах албан тушаалтан
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	-	+		+		
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн багууллагаар хийлгэх	Гэрээний дүнгээр	-	+	+	-	
Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		-	-	+	-	
Байгаль орчны жил бүрийн төлөвлөгөөг байгаль орчны ямаар батлуулж мөрдөн ажиллах	-	+	-	-	+	
Нийт					-	

ДҮГНЭЛТ

“Экспокс” ХХК нь Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8-р хорооны нутаг дэвсгэрт “Палм спрингс” аялал жуулчлалын төслийг 2021 оноос хэрэгжүүлэхээр барилгын ажил явагдаж байгаа ба одоогоор 23 хаус ашиглалтад орсон, үлдсэн барилга байгууламж гадна, дотор, нарийн зэрэг засварын ажил үргэлжилж байна.

Төслийн хүрээнд 2024 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **15,591,500 төгрөг** ба үүнд 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны ажлын зардлууд багтсан болно.